# НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ТҮҮНИЙ ИЛРЭХ ХЭЛБЭР

*Н.Ганхүү. ДХИС-ийн Удирдлагын академийн*
*8022 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

**Товчлол.** Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.1-т “нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ... дэг журам сахиулах” талаар олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хамааруулан заажээ. Нийтийн эмх замбараагүй байдал нь нийтийн хэв журмын хямрал, хууль бус жагсаал, суулт, бослого үймээн, хорлон сүйтгэх үйл ажиллагаа болон бусад төрлийн ийм гэмт хэргүүдийг багтаан авч үздэг байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрийн шийдвэрлүүлэх асуудлынхаа хүрээнд анхаарал хандуулахын тулд зориудаар хууль, дүрэм журмыг биелүүлэхгүй байх явдлаар илэрдэг. Энэхүү өгүүллэгээр нийтийн эмх замбараагүй байдлын тухай ойлголт, холбогдох нэр томьёо, түүний агуулгыг тодорхойлж, хууль тогтоомжид хэрхэн хэрэглэж байгаа талаар харьцуулан судаллаа.

**Түлхүүр үг.** Нийтийн эмх замбараагүй байдал, эмх замбараагүй байдал, олон нийтийн аюулгүй байдал, дэг журам сахиулах.

**Удиртгал.** Өнөөгийн нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал нь шашин хоорондын мөргөлдөөн, улс төрийн нам, эвслүүдийн хэт талцах, хуваагдах зэрэг үйл явц нь иргэд хоорондын болон төр иргэдийн хооронд зөрчилдөөн үүсгэх болж улмаар Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж ноцтой хохирол учруулах байдал буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг үүсгэдэг. Нийтийн эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсад нийтийг хамарсан эмх замбараагүй байдал хэд хэдэн удаа гарч байсан талаар зарим эх сурвалжид дурдсан байдаг. Тухайлбал, 1904 оны Да хүрээний зодоон, 1907 оны лам нарын зодоон, 1912 оны Маймаа хотын зодоон, 1961 оны хятад, монголчуудын зодоон, 1966 оны хятад, монголчуудын зодоон, “Есөн

гудамжны зодоон", 1976 оны Хандгайтын зодоон, Үйлдвэр комбинатын зодоон, 1986 оны Хүнсний хорийн зодооны талаар тус тус дурдсан байна[1].

Монголын эрдэмтдийн цагдаагийн эрх зүйн сурах бичиг болон бусад ном зохиолыг судлан үзвэл нийтийн эмх замбараагүй байдлын талаарх судалгаа эхлэл төдий болох нь харагдаж байна. Доктор (Sc.D) Ж.Долгорсүрэн Цагдаагийн эрх зүйн сурах бичигт "Нийгмийн хэв журам хамгаалах салбарыг удирдах удирдлага" гэсэн хоёрдугаар бүлгийн "Нийгмийн хэв журам, дэг журам, нийтийн аюулгүй байдлын харьцаа"[2], Н.Баярмагнай "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудал" сэдэвт гарын авлагадаа олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэх үед өгөгдөх командын талаар[3], Б.Баянмөнх "Онцгой нөхцөлийн үед хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа"[4], "Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед цагдаагийн байгууллагаас явуулах арга хэмжээний тактик"[5], "Нийтийг хамарсан арга хэмжээний үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажиллагаа (онол, практик)"[6], "Хүний аюулгүй байдлын эрх зүйн асуудал"[7], "Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал"[8], Н.Мөнх-Итгэл "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах,

[1] Б. Ойдов. 20-р зууны монголын түүхэнд гарсан цуутай зодоонууд (хоёрдугаар бүлэг) http://www.bolod.mn/mobile.php?nid=147312

[2] Долгорсүрэн Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. Сурах бичиг. УБ., 2000, 2004, 39, 38 дахь тал

[3] Баярмагнай Н. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудал. УБ., 2013, 66н.

[4] Баянмөнх Б. Онцгой нөхцөлийн үед хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. I дэвтэр, УБ., 2013.

[5] Эрдэнэбаяр Г. Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед цагдаагийн байгууллагаас явуулах арга хэмжээний тактик. (Магистрын ажил) УБ., 2004.

[6] Батбаяр Д. Нийтийг хамарсан арга хэмжээний үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажиллагаа: онол, практик (Магистрын ажил). УБ., 2009.

[7] Амартүвшин А. Хүний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт (Магистрын ажил). УБ„ 2011.

[8] Батмөнх Ж. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал (Магистрын ажил). УБ., 2013.

цагдаагийн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт”[1] сэдэвт магистрын ажлуудыг дурдаж болохоор байна.

Энэхүү өгүүллийн зорилго нь нийтийн эмх замбараагүй байдлын тухай ойлголт, төрлийн талаарх гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан судалж, холбогдох нэр томьёо, түүний агуулга, тэдгээрийн зааг ялгааг гаргаж, судалгааны эргэлтэд оруулах, хөгжүүлэх, практикт хэрэгжүүлэх боломж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэх явдал юм.

**Үндсэн хэсэг.** Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн гуравдугаар бүлгийн 3-т дотоод аюулгүй байдал, 3.3.4.4-т “Нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга, хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болохоос сэргийлнэ”, 3 дугаар бүлгийн 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, ... гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн[2]” гэсэн нь цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үзэл баримтлалыг тодорхойлжээ.

Цагдаагийн албаны тухай 2017 оны хуульд “олон нийтийн аюулгүй байдлыг хангах” гэсэн нэр томьёоны тайлбарыг бий болгож, гүйцэтгэх үүргийг илүү нарийвчлан зохицуулсан. Тухайлбал, 40 дүгээр зүйл “нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ”, 41 дүгээр зүйл “согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох”, 42 дугаар зүйл “согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох”, 43 дугаар зүйл “бүлэг хүмүүсийг тараах”, 44 дүгээр зүйл “жагсаал, цуглааныг албадан тараах” г.м олон нийтийн аюулгүй байдлыг хангах, дэг журам сахиулах, нийтийн эмх замбараагүй байдлын үед гүйцэтгэх үүргийг нарийвчлан тусгажээ. Харин “нийтийн эмх замбараагүй байдал” гэсэн нэр томьёоны талаарх хууль зүйн тайлбар одоогоор байхгүй байна.

Нийтийн эмх замбараагүй байдал гэдэг ойлголт нь хууль зүйн нэр томъёоны хувьд шинэлэг ойлголт мэт харагдах боловч хүн

[1] Мөнх-Итгэл Н. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, цагдаагийн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт (Магистрын ажил). УБ., 2015.
[2] Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол.

төрөлхтний түүхийг сөхөн үзвэл өнө удаан жилийн түүхтэй үйл явц болох нь харагддаг юм. Улс төр, тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцэл, хувьсгал зэрэг үйл явдлууд тодорхой хэмжээгээр нийгмийн дэг журмыг алдагдуулж, эмх замбараагүй байдал үүсгэдэг үр дагавартай.

Англи хэлэнд “нийтийн эмх замбараагүй байдал” гэсэн үг нь

- Civil disorder - нийтийн эмх замбараагүй байдал,
- Civil disturbance- олон нийтийн бухимдал,
- Riot - үймээн самуун,

Дээрх нэр томьёонууд нь “нийтийн эмх замбараагүй байдал” гэсэн утгыг илэрхийлдэг байна.

**Riot буюу** “үймээн самуун” гэдэг нь эрх мэдэл, өмч хөрөнгө, иргэн, олон нийтийн эсрэг хүчирхийлэл үйлдэж, үймээн самуун дэгдээж буй бүлэг этгээдийн үйл ажиллагаа бөгөөд иргэний эмх замбараагүй байдлын нэг хэлбэр юм.

**Civil disturbance** буюу “Олон нийтийн бухимдал” нь цугларсан хүмүүс хашгирч, дуулж, ганцаарчилсан болон хамтын санал бодлоо илэрхийлж, үймээн самуунд хүргэх зорилготой юм.

**Public Disorder** буюу “нийтийн эмх замбараагүй байдал” гэсэн нэр томьёо нийтийн хэв журмын тайван байдал алдагдах, байгууллагуудын ердийн болон хэвийн үйл ажиллагаанд саад учрах, хурцадмал байдал үүсэх, эсхүл үймээн шуугиантай, гэмт хэрэг, хүчирхийлэл зэрэг нөхцөл байдал үүссэн, нийтийн болон нийгмийн дэг журам алдагдах түгшээсэн байдал үүсэхийг хэлнэ.

Нийтийн эмх замбараагүй байдал гэдэг нь гурав буюу түүнээс дээш этгээдүүдийн цугларалтаас бусад хүний эд хөрөнгө гэмтэх, аюул бий болгох, эсвэл хүчирхийллийн үйлдлийг хамарсан үр дүнд үүсгэж буй нөхцөл байдал гэж тодорхойлжээ[1].

Цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа

[1] Civil disturbance operations, https://irp.fas.org/doddir/armv/fm3-19-15.pdf

мөрдлөг болгон ажилладаг бөгөөд хуульд дараах нэр томьёог тайлбарлажээ. Үүнд:

Нийтийн хэв журам хамгаалах[1]- “нийтийн хэв журам хамгаалах” гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг;

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах[2]-гэж хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг тус тус ойлгоно.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 504-т “нийтийн эмх замбараагүй байдал”[3] гэдэг нь олныг хамарсан түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх нөхцөл байдал” гэж тайлбарлажээ.

Академич С.Нарангэрэл “нийтийн эмх замбараагүй байдал буй болох[4]” (mass riot) гэдэг нь Монгол Улсын эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлд заасан нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Энэхүү гэмт хэргийн объектив тал түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирснаар илэрнэ гэж гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээр нь тодорхойлжээ.

Судлаач О.Самбуу “хэсэг бүлгээрээ хамтарч нийгмийн хэв журам зөрчигдсөнөөр зөрчигчдийн тоо эрс өсөж, уг үйлдэл нь бусдад захирагдахгүйгээр өөрсдийн дур зоргоор онцгой танхай

[1] Цагдааагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

[2] Цагдааагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэг.

[3] ЦЕГ-ын даргын А/44 дүгээр тушаал. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 504.2

[4] Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Dictionary of law. УБ., 2008. 2 дахь удаагийн хэвлэл. 295 дахь тал.

шинж чанарыг агуулсан байхыг нийтийн эмх замбараагүй байдал[1]" гэж тодорхойлжээ.

Доктор Д.Булган "Нийтийн эмх замбараагүй байдал" гэдэг нь цугласан олон хүний замбараагүй байдал, хууль, дүрэм биелүүлэхгүй, өөрсдийн дур зоргоороо авирлах, зарим тохиолдолд хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд аюул, занал учруулж болох нийгмийн хэв журмын хүндэрсэн нөхцөл байдал юм" гэж тодорхойлжээ[2].

Ийнхүү гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлд тусгагдсан нэр томьёоны тайлбар, тодорхойлолтуудыг харьцуулан харахад "нийтийн эмх замбараагүй байдал" гэсэн нэр томьёо нь дараах шинжийг агуулж байна. Үүнд:

1) Гурав буюу түүнээс дээш олон тооны хүмүүс оролцдог;

2) Бусдын болон өөрсдийнхөө аюулгүй байдалд аюул учруулж, эд хөрөнгөд хохирол учруулах, заналхийлэх, хууль тогтоомжийг зөрчиж буй үйлдэл;

3) Хүчирхийлллээр дамжуулан зорилгодоо хүрэх, асуудлаа шийдвэрлүүлэхэд чиглэгдсэн хууль бус үйл ажиллагаа байдаг.

Дээрх тодорхойлолт, шинжүүдийг харьцуулан үзвэл нийтийн эмх замбараагүй байдал нь нийтийн хэв журмын хямрал, хууль бус жагсаал, суулт, бослого үймээн, хорлон сүйтгэх үйл ажиллагаа болон бусад олон төрлийн ийм гэмт хэргүүдийг багтаан авч үздэг өргөн хүрээтэй ойлголт байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрийн шийдвэрлүүлэх асуудлынхаа хүрээнд анхаарал хандуулахын тулд зориудаар хууль, дүрэм журмыг биелүүлэхгүй байх явдлаар илэрч болно.

Нийгэмд үүссэн хууль бус ажиллагаа даамжран хяналтаас гаргасан тохиолдолд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам алдагдахад хүрч, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн ажиллагааг тасалдуулан, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөнд

[1] Самбуу О. Нийгмийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр суралцагсдын гарын авлага. УБ., 2006. 32 дахь тал

[2] Булган Д. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Диссертацийн ажил Уб., 2017 он.

халдах замаар уулгалан довтолж, танхайрсан гэмт үйлдлийн улмаас ихээхэн хохирол учирахад хүрдэг байна[1].

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын төрөл нь дараах байдлаар илэрдэг.

> Улс төрийн бослого гэдэг нь улс төрийн зорилгоор, эсхүл улс төрийн эсэргүүцлээс болж үүссэн иргэд, олон нийтийн бослого юм.

> Шорон дахь үймээн самуун гэдэг нь хорих ангийн удирдлага, шоронгийн ажилтнууд эсхүл бусад хоригдлуудын эсрэг хэсэг бүлэг хоригдлууд харилцан ойлголцоогүйн улмаас бие биенээ эсэргүүцэж эмх замбараагүй байдал гаргах явдал юм.

> Race riot бол арьс өнгөөр ялгаварлан гадархуусны улмаас үүсэн эмх замбарагүй байдал юм. Энэхүү эмх замбараагүй байдлын гол хүчин зүйл нь арьсны өнгө, үндэс угсааны асуудал байдаг. Энэ нэр томъёо нь 1890-ээд оноос АНУ-д англи хэл дээр нэвтэрсэн.

> Шашны мөргөлдөөн нь шашны үзэл санаанаас үүдэлтэй үймээн самуун бөгөөд үймээн самууныг дэгдээх гол хүчин зүйл нь шашин шүтлэгийн асуудал байдаг.

> Спортын үймээн самуун нь тодорхой баг, тамирчны ялагдал, ялалтаас үүдэлтэй бөгөөд хоёр багийн хөгжөөн дэмжигчид зодолдож, танхайран эмх замбараагүй байдал үүсгэдэг. АНУ-д спорт бол үймээн самууны хамгийн нийтлэг шалтгаан болдог.

> Байгалийн гамшгийн үед үүссэх эмх замбараагүй байдал. Энэ нь байгалийн гамшиг, гал түймэр, осол, сүйрэлтэй холбогдон үүсэх эмх замбараагүй байдал үүсдэг онцлогтой байдаг. Энэ нь хүний хүсэл зоригоос үл хамааралтай бөгөөд нөхцөл байдлын үед олон нийтийн шилжилт хөдөлгөөн бий болох, балмагдалт, сандралт үүсдэг, зохион байгуулалтгүй нөхцөл байпдал бий болдог.

Нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулагчид нь үймээн самуун дэгдээх, олон түмний шашны болон улс төрийн үзэл,

[1] Нийтийг хамарсан арга хэмжээ нь нийтийн эмх замбараагүй байдлаас ялгагдах гол онцлог нь тайван замаар болдогт оршино. Гэвч нийтийг хамарсан арга хэмжээ нь ямарч нөхцөлд нийтийн эмх замбараагүй байдал болон өөрчлөгдвж болно.

итгэл, үнэмшил, үндэстэн, ястны хоорондын ялгааг юуны түрүүнд ашигладаг байна.[1]

Эмх замбараагүй байдал нь хэд хэдэн үе шаттай. Үүнд:

Эхний үе шат нь хэсэг бүлэг хүмүүс нийтийн эмх замбараагүй байдал үйлдэхээр ирэх үе.

Хоёрдахь шатанд энэ асуудлыг сонирхдоггүй бусад хүмүүс нэгдэж, эд хөрөнгийг тонох, устгах боломжийг ашиглан энэхүү үйл ажиллагаанд нэгдэнэ.

Гурав дахь үе шат нь зохион байгуулалттай тайнхай залуучуудын бүлэглэлүүд нийгэмд хууль бус үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Гурав дахь үе шатанд дээрэм тонуулаас авахуулаад цагдаа, хууль сахиулах байгууллагуудын эсрэг чиглэсэн зэвсэглэсэн дайралт, галдан шатаах зэрэг олон янзын хууль бус ажиллагаа боловсруулан хэрэгжүүлдэг байна.

Үймээн самуун үүсэх эдгээр тодорхой үе шатуудыг харгалзан цагдаа, хууль сахиулах байгууллагууд шуурхай арга хэмжээ авч, хангалттай техник хэрэгсэл, тактикийн төлөвлөгөө, болзошгүй үймээн самууныг хянах хангалттай боловсон хүчнээр хангагдаж, ажиллах ёстой.

Нийтийн эмх замбараагүй байдал, жагсаал, цуглаанд оролцогчдыг гүйцэтгэж байгаа чиг үүрэг, оролцож байгаа хэлбэр зэргээр нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Зохион байгуулагч;
- Оролцогч;
- Сонирхогч;
- Хэв журам зөрчигч;
- Хэв журам сахиулагч;
- Хариуцагч - ихэнхдээ төр, төрийн албан тушаалтан байдаг;
- Ажиглагч;
- Бусад гэж ангилна.

Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн нөхцөл байдалд оролцсон хүмүүс дараах үе шатыг дамждаг байна. Үүнд:

[1] Г.Совд. Үндсэн хуулийн дагалга. - УБ., 1993. 29 дэх тал.

1. Хувь хүний төлөв, мөн чанараа алдаж олон нийтийн зүгээс үзүүлж байгаа тухайн үеийн бодит нөхцөл байдлын нөлөөнд автах үе;

2. Өөрөө шийдвэр гаргах чадваргүй болж, олны урсгалд татагдан орох үе;

3. Эргэн тойрны олон түмний нөлөө /шуугиан/ ихсэх үед сэтгэл зүйн хувьд тэдний уур амьсгалд уусан орох гэсэн үе шаттайгаар нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд татагдан ордог байна[1].

Нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулалтын хэлбэр, үүссэн шалтгаан нөхцөл, хамрах хүрээ, үйл явдал өрнөж буй газрын байршлаас нь хамаарч дараах байдлаар ангилна. Тухайлбал:

| Зохион байгуулалтын хэлбэрээр нь: | Нутаг дэвсгэрийн хамрах хүрээгээр нь: | Үүссэн газар, орчны байдлаар нь: |
|---|---|---|
| ➢ Урьдаас төлөвлөсөн;<br>➢ Төлөвлөгдөөгүй буюу тодорхой нөхцөл байдлын улмаас үүссэн;<br>➢ Нөхцөл байдлын улмаас аяндаа бий болсон. | ➢ Улсын;<br>➢ Бүсийн;<br>➢ Тодорхой нутаг дэвсгэр *(аймаг, нийслэл, сум, дүүрэг);*<br>➢ Тодорхой байгууллага аж ахуйн нэгж. | ➢ Барилга, байгууламж дотор;<br>➢ Гудамж, талбай, олон нийтийн газарт;<br>➢ Хот суурин газрын гадна орчинд гэж ангилдаг. |

Нийтийн эмх замбараагүй байдалд хүргэж байгаа шалтгаан нөхцөлийг тал бүрээс нь судлан дүгнэвэл гол төлөв төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын гаргасан хууль бус, оновчгүй, цаг үеэ олоогүй шийдвэрүүд болон үйл ажиллагаа, зохион байгуулалтын удирдлагын хүнд суртлыг иргэд, олон нийт хүчтэй эсэргүүцэж, ийнхүү эсэргүүцлээ зохион байгуулалттай хэлбэрт оруулан хууль бус жагсаал, цуглаан хийх энэ нь тодорхой үр дүнд хүрэхгүй тохиолдолд тэмцлийн өөр хэлбэр лүү шилжих, улмаар хурц хэлбэр лүү хөрвөн орох зэргээс үүдэлтэй байдаг. [1]

[1] Цахим эх сурвалж, холбоос: https://mn.wiktionary.org/wiki/

Нийтийн эмх замбараагүй байдлын талаар судалгаа хийх явцад уг үзэгдлийн гол цөм болсон “олон нийт”-ийн сэтгэл зүйн онцлогийг заавал судлах шаардлага гардаг.

Олон нийтийн сэтгэл зүйн талаар судалгаа хийхийн тулд “бүлэг бөөгнөрөл” гэсэн ойлголтыг зайлшгүй тайлбарлах хэрэгтэй юм. Бүлэг бөөгнөрөл гэдэг ойлголт нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын явцад хэрэглэдэг онолын гэхээсээ илүү практикт өргөн хэрэглэж ирсэн ойлголт бөгөөд цагдаагийн алба хаагчид бүлэг бөөгнөрөлийн шинжийг дараах байдлаар томьёолон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ирсэн. Үүнд:

Бүлэг бөөгнөрөл нь:

- Бүлэг бөөгнөрөлийн дунд эрэмбэ дараалал үгүй;
- Нийгмийн харилцаа хязгаарлагдсан;
- Бүлэг бөөгнөрөл үүсгэх үйл ажиллагаанд бэлэн;
- Эдгээр бүлэг бөөгнөрөлийн оршин байх хугацаа нь түр зуурын гэх мэт.

Бүлэг бөөгнөрлийн ерөнхий шинж.



Философийн ухааны доктор, профессор Б.Даш-Ёндон “Орчин үеийн монголын нийгмийн бүтэц, оюуны амьдралын тухайд” судалгааны өгүүлэлдээ нийгмийн бүтцийн ялгаатай ойлголтууд болох ард түмэн (народ), бөөн түмэн (масса), хөөрсөн түмэн эсхүл хөлхөлдөгч түмэн (толпа), үзэгч түмэн (публика) зэрэг ойлголтуудыг зааглан ялгаж онцлогуудынх нь талаар бодол санаагаа илэрхийлсэн. Мөн “Преступная толпа” хэмээх орчуулгын бүтээлд эмх замбараагүй байдал үүсэхэд тухайн үйл явдалд оролцогчдын сэтгэл зүйн байдал хэрхэн нөлөөлдөгийг олон талаас нь бодитой тайлбарласан байдаг.

Нийтийн эмх замбараагүй байдлын үед түүнд оролцогчдын нэг онцлог нь гэнэт зохион байгуулалтанд ордог явдал юм. Тиймээс нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдалд оролцогчид нь нийтлэг зорилгод хүрэх гэсэн, урьдчилан ямар нэг эрмэлзэл байдаггүй боловч эцсийн үр дүнд ноцтойгоор уршиг бий болгодогт нэг онцлог нь байдаг. Нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдалд оролцогчдын сэтгэл зүйн шалтгаан, хөдөлгөгч хүчний талаар тодорхой нарийн судлах шаардлагатай.

Эмх замбараагүй байдалд оролцогчдын сэтгэл зүйн онцлог: Олонхийн хүсэл зориг тухайн хүний хүсэл зоригоос чухлаар тавигдана.

- Сэтгэл хөдлөл-тухайн орчинд сэтгэл хөдлөлөө шууд илэрхийлдэг учир эмх замбараагүй байдал үүсэхэд нөлөөлдөг.
- Бусдыг дууриах-Нийгмийн дунд хувь хүн бусдаас хамааралтай амьдардаг учраас бусдын хийсэн үйлдлийг дууриах нь элбэг тохиолддог.
- Бусдын нөлөөлөлд орох-эмх замбараагүй байдлын үед хувь хүн ойр хавийнхны нөлөөлөлд автагдах нь элбэг.
- Танигдахгүй байх гэсэн бодол- хувь хүн эмх замбараагүй байдлын үед өөрийгөө танигдахгүй гэсэн бодлоор хууль зөрчдөг.
- Азаа үзэх-яадаг ч байсан бүгд л хийж байгаа юм чинь юу л болов гэсэн бодол.

Эмх замбараагүй байдал нь хувь хүнд бодох зав өгдөггүй нь бодлогогүй алхам хийхэд хүргэх нь их бөгөөд олон нийт буюу бүлэг бөөгнөрөлийн сэтгэл зүйн онцлогууд нь эмх замбараагүй байдлын үед дараах үе шатуудаар илэрдэг гэж үзэж болно.

- Удирдагчид буюу гол зохион байгуулагчид тодрох үе шат
- Бусдыг зоригжуулах, өдөөн хатгах үе шат
- Бүлэг бөөгнөрөлийн тоо хэмжээ өсөх үе шат
- Сэтгэл зүйн бэлтгэлийн үе шат
- Үйл явдлыг хурдасгасан байдал
- Хяналтаа алдаж, хүч хэрэглэх үе шат
- Эмх замбараагүй байдал тархаж газар авах үе шат

Дээр дурьдсан зүйлээс үзэхэд эмх замбараагүй байдал, үймээн самууны үйл явцыг эрдэмтэн судлаачид олон талаас нь судалж байсан нь харагдаж байна. Одоогоос 100 гаруй жилийн өмнө л гэхэд эмх замбараагүй байдал, түүнд оролцогчдын сэтгэл зүйн байдал, нөлөөлөх хүчин зүйлийг антропологи, нийгэм, эрх зүйн хувьд судалж маш сонирхолтой үзэл санааг дэвшүүлж байсан нь одоо ч үнэ цэнээ алдахгүй байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед нийтийн сэтгэл зүйг харгалзан үзэж, эмх замбараагүй байдлыг бий болгоход түлхэц өгч буй онгироо, сагсуу, бүдүүлэг эрээ цээргүй хүмүүсийг оновчтой тодорхойлон тэдний дунд тайвшруулах, ухуулан сэнхрүүлэх, нөхцөл байдлыг зөв ойлгуулах ажиллагааг хийвэл эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаа үр дүнтэй болно.

**Дүгнэлт.** Нийтийн эмх замбараагүй байдал бий болох нөхцөл байдал нь аль ч улс орны хувьд ардчилсан замаар нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадаж байгаа эсэх, улс төр, соёлын хөгжлийн түвшин, тэрчлэн тухайн орны үндэсний түүхэн уламжлал, зан заншил, шашин, улс төрийн өндөр дээд болон удирдах албан тушаалтны улс орноо удирдан авч явах ур чадвар, нийгэм-эдийн засгийн чадавхи зэрэг олон хүчин зүйлээс хамаарч бий болж байна.

Дээрх судалгаанд үндэслэн дараах тодорхойлолтыг хийлээ. Үүнд: “иргэд олноороо нийтээр тогтоосон хэв журмыг бүлэглэн зөрчиж, хуулиар хориглосон, гэмт хэрэг, зөрчилд тооцогдох үйлдлүүдийг гаргах замаар нийгмийн тогтолцоог алдагдуулахад чиглэсэн хурцадмал өрнөл бүхий шинжтэй нөхцөл байдлыг “нийтийн эмх замбараагүй байдал” гэж үзэж болохоор байна.